11.11 Шалгуулагч 11.1-11.5-д заагдсан аль нэг шалтгааны улмаас шалгалтаас хасагдсан бол доод тал нь 3 сарын дараа дахин шалгалт өгч болно.

11.12 Зүйл 11.6 (шалгуулагч өөрийн мөн эсэхийг хуурах) болон 11.7 (авлига)-ын улмаас шалгалтаас хасагдах тохиолдолд Гёте-Институт тухайн тохиолдлын нөхцөл байдлыг дэнслэн үзэж оролцогчид дэлхий даяарх бүх Гёте-Институтийн шалгалтын хүрээнд нэг (1) жилийн хориг тавина (§ 3-тай харьцуул). Үүний тулд (шалгалтын хоригийн хэрэгжилтийг хянах) хориг тавиулсан хүний овог нэр, төрсөн огноо, төрсөн газар, хориг тавьсан хугацаа зэрэг хувийн тодорхой мэдээллүүдийг шалгалтын төв нь дэлхий даяарх Гёте-Институтийн шалгалтын төвүүдэд мэдэгдэж (§ 2-г харна уу), тэдгээр нь тус тусын боловсруулалтыг хийнэ. § 15-г мөн харна уу.

11.13 Шалгалт дууссаны дараа 11.1-11.7 зүйлд заасан шалгалтаас хасах үндэслэл бүрдсэн сэжигтэй тохиолдол илэрвэл шалгалтын комисс шалгуулагчийг шалгалтад унасанд тооцож, сертификат олгосон бол буцаан хураах эрхтэй. Шалгалтын комисс тухайн шийдвэрийг гаргахаас өмнө тус шалгуулагчийн тайлбарыг сонсоно. Эргэлзээтэй нөхцөлд Гёте-Институтийн төвд мэдэгдэж, асуудлыг шийдвэрлүүлнэ. Энэ тохиолдолд 11.11 болон 11.12-т заасан хоригийн хугацаа хүчин төгөлдөр үйлчилнэ.

## § 12 Шалгалт цуцлах болон шалгалтыг дундаас нь орхих

12.1 Хууль ёсны эсэргүүцэх эрхийг харгалзан дараах зүйлс хүчинтэй үйлчилнэ: Шалгалтад оролцогч шалгалтыг өгөхгүй байх (цуцлах)-аар шийдвэл хэдийн төлсөн төлбөрийг буцаан олгохыг шаардах эрхгүй. Дэлгэрэнгүйг Үйл ажиллагааны ерөнхий нөхцөлөөр зохицуулсан байна. Шалгалтыг эхэлсний дараа орхивол шалгалтад тэнцээгүйд тооцно.

12.2 Wird eine Prüfung nicht begonnen oder nach Beginn abgebrochen und werden dafür Krankheitsgründe geltend gemacht, sind diese unverzüglich durch Vorlage eines ärztlichen Attests beim zuständigen Prüfungszentrum nachzuweisen. Die Entscheidung über das weitere Vorgehen trifft das Prüfungszentrum nach Rücksprache mit der Zentrale des Goethe-Instituts.

12.3 Hinsichtlich der Rückerstattung der Prüfungsgebühren gilt 6.2 und 6.3.

### § 13 Mitteilung der Prüfungsergebnisse

Die Mitteilung der Prüfungsergebnisse erfolgt in der Regel über das Prüfungszentrum, an dem die Prüfung abgelegt wurde. Eine individuelle vorzeitige Ergebnismitteilung ist nicht möglich.

### § 14 Zertifizierung

14.1 Die Zertifikate werden in Papierform oder digital ausgestellt. Die Form der Ausstellung der Zertifikate hängt von den Gegebenheiten am Prüfungszentrum vor Ort ab. Es besteht hierbei kein Anspruch auf die Ausstellung eines Zertifikats in der jeweils anderen Form. Die Gültigkeit von Goethe-Zertifikaten kann auf der Website [www.goethe.de/verify](http://www.goethe.de/verify) überprüft werden.

14.2 Das Zeugnis in Papierform wird in einfacher Ausfertigung ausgestellt und ist von dem/der Prüfungsverantwortlichen und einem/einer Prüfenden unterschrieben (vgl. § 16).

14.3 Digitale Zeugnisse werden den Prüfungsteilnehmenden als PDF-Datei zur Verfügung gestellt.

14.4 Im Falle des Zeugnisverlusts kann durch das Prüfungszentrum, bei dem sich die Teilnehmenden für die Prüfung angemeldet haben, innerhalb von 10 Jahren eine Ersatzbescheinigung ausgestellt werden. Die Ausstellung einer Ersatzbescheinigung ist kostenpflichtig.

12.2 Өвчний улмаас шалгалтаа эхлүүлээгүй эсвэл эхэлсний дараа больсон тохиолдолд тухайн шалгалтын төвд даруй эмчийн магадлагаа өгнө. Шалгалтын төв Гёте-Институтийн төвтэй ярилцсаны үндсэн дээр цаашдын арга хэмжээг авна.

12.3 Шалгалтын төлбөрийн тухайд 6.2 болон 6.3 зүйл үйлчилнэ.

### § 13 Шалгалтын дүнг мэдэгдэх

Шалгалтын дүнг шалгалт авсан төв мэдэгдэх ба дүнг нэг хүнд ганцаарчлан урьдчилан мэдэгдэх боломжгүй.

### § 14 Сертификат олгох

Сертификатыг цаасан болон дижитал хэлбэрээр олгоно. Ямар хэлбэрээр олгох нь тухайн шалгалтын төвийн нөхцөлөөс хамаарна. Сертификатыг өөр хэлбэрээр олгохыг шаардах эрхгүй. Гёте-Институтийн сертификатын хүчин төгөлдөр эсэхийг [www.goethe.de/verify](http://www.goethe.de/verify) цахим хуудсаар шалгаж болно.

14.2 Цаасан сертификат энгийн хэлбэрээр гарах ба түүн дээр шалгалтын хариуцлагатай ажилтан болон нэг шалгагч гарын үсэг зурна (§ 16 тай харьцуул).

14.3 Дижитал сертификатыг шалгалтад оролцогчдод PDF-хэлбэрээр олгоно.

14.4 Сертификатыг хаяж гээгдүүлсэн тохиолдолд 10 жилийн дотор шалгуулагчийн бүртгүүлсэн шалгалтын төв орлуулах бичиг олгож болно. Орлуулах бичиг нь үнэ төлбөртэй байна.

14.5 Die Prüfungsleistungen werden in Form von Punkten und gegebenenfalls sich daraus ableitenden Prädikaten dokumentiert. Das Prüfungszentrum weist bei Nichtbestehen auf die Bedingungen zur Wiederholung der Prüfung hin. Die Teilnahme an einer abgelegten, aber nicht bestandenen Prüfung wird unter Nennung der erhaltenen Punktwerte auf Wunsch bestätigt.

14.6 Prüfungsteilnehmende, die unten stehende nicht-modulare Prüfungen in allen Teilen abgelegt und bestanden haben, erhalten jeweils ein Gesamtzeugnis, welches die Ergebnisse von allen vier Prüfungsteilen ausweist:

- GOETHE-ZERTIFIKAT A1: FIT IN DEUTSCH 1
- GOETHE-ZERTIFIKAT A1: START DEUTSCH 1
- GOETHE-ZERTIFIKAT A2 FIT IN DEUTSCH
- GOETHE-ZERTIFIKAT A2
- GOETHE-ZERTIFIKAT C1 (bis 31.01.2025)

14.7.1 Prüfungsteilnehmende, die ein Modul oder mehrere Module der Prüfungen

- GOETHE-ZERTIFIKAT B1
- GOETHE-ZERTIFIKAT B2
- GOETHE-ZERTIFIKAT C1 (modular ab 01.01.2024)
- GOETHE-ZERTIFIKAT C2: GROSSES DEUTSCHES SPRACHDIPLOM

abgelegt und bestanden haben, erhalten je ein Zeugnis über das oder die abgelegte(n) Modul(e).

14.7.2 Werden alle vier Module an **einem** Prüfungsort und **einem** Prüfungstermin abgelegt und bestanden, haben die Prüfungsteilnehmenden alternativ das Recht auf ein Gesamtzeugnis., das alle vier Module ausweist.

14.7.3 Werden zu einem späteren Zeitpunkt ein oder mehrere Module erneut abgelegt, sind die dafür erhaltenen Zeugnisse mit bereits zuvor erworbenen kombinierbar.

14.7.4 Sofern es die organisatorischen Möglichkeiten am Prüfungszentrum erlauben, kann auf Wunsch zusätzlich ein Gesamtzeugnis ausgestellt werden. Auf dem Gesamtzeugnis werden die besten Ergebnisse, die innerhalb eines Jahres in den vier Modulen erzielt wurden, aufgeführt.

Das Gesamtzeugnis bescheinigt das Bestehen aller vier Module innerhalb eines Jahres

- an Goethe-Instituten innerhalb der Europäischen Union
- an Goethe-Instituten in Drittstaaten innerhalb eines Landes.

14.5 Шалгалтын дүнг оноо болон түүнд хамаарах дүн хэлбэрээр баримтжуулна. Шалгалтад тэнцээгүй тохиолдолд шалгалтын төв нь давтан шалгалтын нөхцөлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгнө. Хүсвэл тэнцээгүй шалгалтад авсан оноо бүхий тодорхойлолт авч болно.

14.6 Дараах нэгдсэн шалгалтын бүх хэсгийг өгч тэнцсэн оролцогч шалгалтын дөрвөн модуль хэсэг бүрийн оноо бүхий нэгдсэн сертификат авна:

GOETHE ZERTIFIKAT A1: FIT IN DEUTSCH 1  
 GOETHE ZERTIFIKAT A1: START DEUTSCH 1  
 GOETHE ZERTIFIKAT A2 FIT IN DEUTSCH  
 GOETHE ZERTIFIKAT A2  
 GOETHE ZERTIFIKAT C1 (2025.01.31 хүртэл)

14.7.1 Дараах

- GOETHE ZERTIFIKAT B1
- GOETHE ZERTIFIKAT B2
- GOETHE-ZERTIFIKAT C1 (2024.01.01-с эхэлнэ)
- GOETHE ZERTIFIKAT C2: GROSSES DEUTSCHES
- SPRACHDIPLOM

шалгалтыг өгч тэнцсэн тохиолдолд тухайн тэнцсэн модуль хэсгийн сертификатыг авна.

14.7.2 Шалгалтын бүх дөрвөн модуль хэсгийг нэг газар, нэг тов дээр өгч тэнцсэн оролцогч бүх дөрвөн модуль хэсгийн дүнг баримтжуулсан нэгдсэн сертификат авах эрхтэй.

14.7.3 Дараагийн өөр тов дээр нэг болон нэжгээд хэсгийг өгсөн бол түүгээр авсан сертификатыг өмнө авсантайгаа хослуулж болно.

14.7.4 Шалгалтын төв зохион байгуулалтын хувьд боломжтой бол шалгуулагчийн хүсэлтийн дагуу нэмэлтээр нэгдсэн сертификат олгож болно. Нэгдсэн сертификат дээр нэг жилийн дотор өгсөн дөрвөн хэсэг шалгалтын хамгийн сайн авсан дүн бичигдэнэ.

Нэгдсэн сертификат нь нэг жилийн дотор

- Европын холбоон дахь Гёте-Институтууд
- гуравдагч орнуудад байх Гёте-Институтуудад өгсөн шалгалтын бүх дөрвөн модульд тэнцсэнийг баталгаажуулна.

14.7.5 Institutsübergreifende Gesamtzeugnisse können nur von Goethe-Instituten ausgestellt werden, an denen mindestens ein Modul erfolgreich abgelegt wurde.

14.7.6 An Goethe-Zentren und bei PrüfungsKooperationspartnern kann ein Gesamtzeugnis ausgestellt werden, wenn alle vier Module **innerhalb eines Jahres am gleichen Prüfungszentrum** bestanden wurden.

14.7.7 Das jeweils zuständige Prüfungszentrum entscheidet über die Erhebung einer Verwaltungsgebühr in Höhe von bis zu 25 % der Prüfungsgebühr für die Ausstellung eines Gesamtzeugnisses.

### § 15 Wiederholung der Prüfung

Die in 14.6 und 14.7.1 genannten Prüfungen können als Ganzes beliebig oft wiederholt werden; für die in 14.7.1 genannten modularen Prüfungen besteht darüber hinaus die Möglichkeit, auch einzelne Module beliebig oft zu wiederholen.

Vom Prüfungszentrum können bestimmte Fristen für einen Wiederholungstermin festgelegt werden. Auf diese wird bei der Mitteilung des Prüfungsergebnisses hingewiesen. Ein Rechtsanspruch auf einen bestimmten Prüfungstermin besteht nicht. Siehe auch 3.3 bis 3.5, 3.7 sowie 11.11 bis 11.13.

### § 16 Prüfungskommission

Für die Abnahme und ordnungsgemäße Durchführung der Prüfung beruft das Prüfungszentrum eine Prüfungskommission ein, die sich aus zwei Prüfenden zusammensetzt, von denen in der Regel eine/-r der/die Prüfungsverantwortliche des jeweiligen Prüfungszentrums ist.

### § 17 Protokoll über die Durchführung der Prüfung

Über den Verlauf der Prüfung wird ein Protokoll (im Print- oder Digitalformat) angefertigt. Darin werden die Daten zur jeweiligen Prüfung (Prüfungsteilnehmende/-r, Prüfungszentrum, Prüfungstermin u. a.) einschließlich Uhrzeit und besondere Vorkommnisse während der Prüfung festgehalten.

14.7.5 Институт дамнаулан авах нэгдсэн сертификатыг зөвхөн доод тал нь нэг модуль хэсгийг амжилттай өгч тэнцсэн Гёте-Институтууд олгоно.

14.7.6 Гёте төвүүд болон Гёте-Институтийн шалгалтын түнш байгууллагууд шалгалтын бүх дөрвөн модуль хэсгийг нэг жилийн дотор шалгалтын нэг төв дээр өгсөн тохиолдолд нэгдсэн сертификатыг олгох боломжтой.

14.7.7 Шалгалтын тухайн төв нэгдсэн сертификатыг олгоход шалгалтын төлбөрийн 25 % хүртэлх үнийн дүнгийн захиргааны зардлыг нэхэмжлэх эсэхээ шийднэ.

### § 15 Шалгалтыг давтан өгөх

14.6 болон 14.7.1-д заасан шалгалтуудыг бүтнээр нь хүссэнээрээ, 14.7.1-д заасан модулиар хэсэгчилсэн шалгалтуудын модуль тус бүрийг хэсэгчлэн хүссэн тоогоор давтан өгч болно.

Шалгалтын төв дахин өгөх шалгалтын тодорхой хугацаа заасан товыг тогтоож болно. Энэ талаар шалгалтын дүнг мэдэгдэхэд мэдээлнэ. Шалгалтын тодорхой товыг шаардах эрх байхгүй болно. 3.3 - 3.5, 3.7 болон 11.11 - 11.13.заалтуудыг харна уу.

### § 16 Шалгалтын комисс

Шалгалтыг журмын дагуу авч, зохион байгуулахын тулд шалгалтын төв нь шалгалтын комисс байгуулна. Тус комисс нь ихэвчлэн хоёр шалгагчаас бүрдэх ба тэдний нэг нь тухайн төвийн шалгалтын хариуцлагатай ажилтан байна.

### § 17 Шалгалтын хэрэгжүүлэлтийн талаарх протокол

Шалгалтын явцын талаар протокол хөтөлнө. Протоколд тухайн шалгалтын холбогдолтой мэдээлэл (шалгуулагч, шалгалтын төв, шалгалтын тов), шалгалтын цаг болон шалгалтын үеэр гарсан онцгой зүйлсийг тэмдэглэн үлдээнэ.

## § 18 Befangenheit

Die Besorgnis der Befangenheit eines/einer Prüfenden kann der/die Prüfungsteilnehmende nur unverzüglich und nur vor Beginn der mündlichen Prüfung vorbringen.

Die Entscheidung über die Mitwirkung des/der Prüfenden trifft der/die Prüfungsverantwortliche.

In der mündlichen Prüfung hat mindestens einer der beiden Prüfenden keine/-n Prüfungsteilnehmende/-n im letzten vor der Prüfung von der/dem Prüfungsteilnehmenden besuchten Kurs unterrichtet. Ausnahmeregelungen bedürfen der Genehmigung durch die Zentrale des Goethe-Instituts.

## § 19 Bewertung

Die Prüfungsleistungen werden von zwei Prüfenden/Bewertenden voneinander unabhängig bewertet. Im schriftlichen Prüfungsteil werden nur solche Markierungen und Texte bewertet, die mit zulässigen Schreibwerkzeugen erstellt wurden (Kugelschreiber, Füller, Faser- oder Gelstifte in Schwarz oder Blau). Die Einzelheiten sind den jeweiligen *Durchführungsbestimmungen* zu entnehmen.

## § 20 Einsprüche

20.1 Ein Einspruch gegen das **Prüfungsergebnis** ist innerhalb von zwei Wochen nach Bekanntgabe des Prüfungsergebnisses in Textform bei der Leitung des Prüfungszentrums, an dem die Prüfung abgelegt wurde, zu erheben.

Unbegründete oder nicht ausreichend begründete Anträge kann der/die Prüfungsverantwortliche zurückweisen. Der bloße Hinweis auf eine nicht erreichte Punktzahl ist als Begründung nicht ausreichend.

20.2 Der/Die Prüfungsverantwortliche am Prüfungszentrum entscheidet darüber, ob dem Einspruch stattgegeben wird. In Zweifelsfällen wendet er/sie sich an die Zentrale des Goethe-Instituts und diese entscheidet darüber. Die Entscheidung über die Bewertung ist endgültig.

20.3 Ein Einspruch gegen die **Durchführung** der Prüfung ist unverzüglich nach Ablegen der Prüfung bei der Leitung des zuständigen Prüfungszentrums, an dem die Prüfung abgelegt wurde, in Textform zu erheben. Der/Die Prüfungsverantwortliche holt die Stellungnahmen aller Beteiligten ein, entscheidet über den Einspruch und verfasst eine Aktennotiz über den Vorgang. In Zweifelsfällen entscheidet die Zentrale des Goethe-Instituts.

## § 18 Хамааралтай байх

Шалгуулагч нь аль нэг шалгагчийг таньдагийн улмаас сэтгэл зовниж байгаа бол тэр даруйд болон шалгалт эхлэхийн өмнө мэдэгдэж болно. Тус тохиолдолд тухайн шалгагчийг ажиллуулах эсэхийг шалгалтын хариуцлагатай ажилтан шийднэ.

Аман шалгалтад орж буй шалгуулагчийн шалгалтаас өмнө суралцсан ангид хоёр шалгагчийн дор хаяж нэг нь хичээл ороогүй байх ёстой. Тусгай зохицуулалт хийх бол Гёте-Институтийн төвөөс зөвшөөрөл авна.

## § 19 Дүгнэх

Шалгалтын ажлыг хоёр шалгагч бие биеэс хамааралгүйгээр дүгнэнэ. Шалгалтын бичгийн хэсэгт зөвхөн зөвшөөрөгдсөн бичгийн хэрэгслээр (хар эсвэл хөх өнгийн бал, үзэг, эсгий үзэг болон гелэн бал) бичсэн тэмдэглэгээ, бичвэрийг дүгнэнэ. Дэлгэрэнгүйг тухайн шалгалтын хэрэгжүүлэлтийн журмаас үзнэ үү.

## § 20 Санал үл нийлэх

20.1 Шалгалтын дүнтэй санал нийлэхгүй байгаа бол шалгалтын дүн гарснаас хойш хоёр долоо хоногийн дотор шалгалт өгсөн төвийн удирдлагад бичгээр мэдэгдэнэ. Үндэслэлгүй эсвэл хангалттай үндэслэл дурдаагүй өргөдлийг шалгалтын хариуцлагатай ажилтан буцааж болно. Хангалтгүй оноо авсан гэж бичих нь хангалттай тайлбар болохгүй.

20.2 Шалгалтын хариуцлагатай ажилтан өргөдлийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ. Эргэлзээтэй тохиолдолд Гёте-Институтийн төвд хандан шийдвэрлүүлнэ. Үнэлгээний талаарх тухайн шийдвэр нь эцсийнх байна.

20.3 Шалгалтын хэрэгжүүлэлтийн талаарх санал гомдлыг шалгалт өгсөн төвийн удирдлагад шалгалт өгсний дараа шууд мэдэгдэнэ. Шалгалтын хариуцлагатай ажилтан бүх оролцогч талуудын байр суурь, мэдэгдлийг хүлээн авч, санал гомдлыг шийдвэрлэн тухайн явцын талаар тэмдэглэл хөтөлнө. Эргэлзээтэй тохиолдолд Гёте-Институтийн төвд хандан шийдвэрлүүлнэ.

20.4 Wird einem Einspruch stattgegeben, so gilt hinsichtlich der Prüfungsgebühren 6.4. Der/Die Teilnehmende kann nach seiner/ihrer Wahl statt einer Rückerstattung die Prüfung kostenlos wiederholen.

### § 21 Einsichtnahme

Prüfungsteilnehmende können auf Antrag nach Bekanntgabe der Prüfungsergebnisse Einsicht in ihre Prüfung nehmen. Der Antrag beschränkt geschäftsfähiger Minderjähriger bedarf der Einwilligung des/der gesetzlichen Vertreters/Vertreterin. Die Einsichtnahme muss in Begleitung des/der gesetzlichen Vertreters/Vertreterin erfolgen.

### § 22 Verschwiegenheit

Die Mitglieder der Prüfungskommission (vgl. § 16) bewahren über alle Prüfungsvorgänge und Prüfungsergebnisse gegenüber Dritten Stillschweigen.

### § 23 Geheimhaltung

Alle Prüfungsunterlagen sind vertraulich. Sie unterliegen der Geheimhaltungspflicht und werden unter Verschluss gehalten.

### § 24 Urheberrecht

Alle Prüfungsmaterialien sind urheberrechtlich geschützt und werden nur in der Prüfung verwendet. Eine darüberhinausgehende Nutzung, insbesondere die Vervielfältigung und Verbreitung sowie öffentliche Zugänglichmachung dieser Materialien ist nicht gestattet. Verstöße werden urheberrechtlich verfolgt.

20.4 Эсэргүүцэл гомдлыг хүлээн авсан тохиолдолд шалгалтын төлбөрийн хувьд 6.4. заалт үйлчилнэ. Шалгалтад оролцогч нь буцаан олголт авах эсвэл шалгалтыг дахин өгөхөө шийдэж болно.

### § 21 Шалгалтын материалтай танилцах

Шалгуулагч нь шалгалтын дүн гарсны дараа хүсэлт гарган шалгалтын материалтай танилцаж болно. Хариуцах чадвартай насанд хүрээгүй оролцогч хүсэлт гаргахдаа хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрлийг авсан байна. Энэ тохиолдолд шалгалтын материалтай танилцахад хууль ёсны асран хамгаалагч нь дагалдана.

### § 22 Дуугүй байх

Шалгалтын комиссийн гишүүд (§ 16-тай харьцуул) шалгалтын явц, дүнгийн талаар гуравдагч этгээдэд мэдээлэхгүй байх үүрэгтэй.

### § 23 Нууцлалыг хадгалах

Шалгалтын бүх бичиг баримт нууц бөгөөд нууцлалыг хадгалах үүргийн дагуу цоожтой хадгалагдана.

### § 24 Зохиогчийн эрх

Шалгалтын бүх бичиг баримт зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд зөвхөн шалгалтад хэрэглэгдэнэ. Тэдгээр материалыг олшруулах, олон нийтэд хүртээл болгох, тараах зэрэг хэрэглээг хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд зохиогчийн эрхийн журмаар шийдвэрлэнэ.



## § 25 Archivierung

Die papierbasierten und digitalen Prüfungsunterlagen der Prüfungsteilnehmenden werden 12 Monate, gerechnet vom Prüfungstermin an, unter Verschluss aufbewahrt und dann fachgerecht entsorgt (Papierunterlagen) oder gelöscht (digitale Daten).

Das Dokument über das Gesamtergebnis oder bei modularen Prüfungen das Ergebnis des jeweiligen Moduls wird 10 Jahre lang aufbewahrt und dann fachgerecht entsorgt oder gelöscht.

## § 26 Qualitätssicherung

Die gleichbleibend hohe Qualität der Prüfungsdurchführung wird durch regelmäßige Kontrollen der schriftlichen und mündlichen Prüfung im Rahmen von Hospitationen sowie durch Einsichtnahme in die Prüfungsunterlagen sichergestellt (vgl. § 8). Der/Die Prüfungsteilnehmende erklärt sich damit einverstanden.

## § 27 Datenschutz

Alle an der Durchführung der Prüfung Beteiligten sind zur Geheimhaltung und zur Einhaltung der anwendbaren Datenschutz-Vorschriften verpflichtet. Das Goethe-Institut darf auf Anfrage von öffentlichen Behörden im Fall des begründeten Verdachts der Fälschung eines Goethe-Zertifikats die Echtheit des Goethe-Zertifikats bestätigen oder widerlegen.

## § 28 Schlussbestimmungen

Diese *Prüfungsordnung* tritt am 1. September 2023 in Kraft und gilt für Prüfungsteilnehmende, deren Prüfung nach dem 1. September 2023 stattfindet.

Im Falle von sprachlichen Unstimmigkeiten zwischen den einzelnen Sprachversionen der *Prüfungsordnung* ist für den unstimmigen Teil die deutsche Fassung maßgeblich.

## § 25 Архивлах

Шалгуулагчдын цаасан болон дижитал хэлбэрийн шалгалтын материалуудыг 12 сар цоожлон хадгалж, дараа нь (цаасан болон дижитал материалуудыг) журмын дагуу устгана.

Дүнгийн нэгдсэн хүснэгт болон хэсэгчилсэн модуль шалгалт авсан бол дүнгийн хүснэгтийг 10 жил хадгалж, эцэст нь журмын дагуу устгана.

## § 26 Чанар хангах

Шалгалтын хэрэгжилтийг байнга чанарын өндөр түвшинд байлгахын тулд аман болон бичгийн шалгалтад байлцах, шалгалтын материалуудыг үзэж хянах аргаар хяналт тавина (§ 8-харьцуул). Шалгалтад оролцогч үүнийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

## § 27 Мэдээллийн хамгаалалт

Шалгалтын зохион байгуулалтад оролцогч бүх хүн хэрэглээний мэдээллийн хамгаалах дүрэм журмыг баримтлан нууцлах үүрэгтэй. Гёте-Институт Гёте-Сертификатыг хуурамчаар үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжигтэй тохиолдолд олон нийтийн байгууллагуудын хүсэлтээр сертификатыг үнэн зөв эсэхийг тогтоож болно.

## § 28 Төгсгөл

Шалгалтын энэхүү журам нь 2023 оны есдүгээр сарын нэгнээс хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаанаас хойш зохион байгуулагдах шалгалтад оролцогчдод үйлчилнэ.

Өөр хэлнүүд дээрх шалгалтын журамд үл таарч тохирох зүйл гарвал тэрхүү хэсгийн герман хэл дээрх хувилбарыг баримтална.

---

Legende zu Formatierungen:

VERSAL: Prüfungsnamen und Prüfungsteile (z. B. GOETHE-ZERTIFIKAT B1)

kursiv: Dokumentenbezeichnungen, Eigennamen, Verweise (z. B. *Protokoll über die Durchführung der Prüfung*)



**ANHANG****Zusätzliche Regelungen zu digitalen Deutschprüfungen**

Wird die Prüfung digital am Prüfungszentrum abgelegt, gilt abweichend Folgendes:

**Abweichend zu § 19:**

Bei digitalen Deutschprüfungen werden Aufgaben mit vorgegebenen Antwortmöglichkeiten in den Modulen LESEN und HÖREN technisch automatisiert durch die Testplattform bewertet. Beim Prüfungsteil/Modul SCHREIBEN werden nur die Texte bewertet, die in das entsprechende Textfeld eingetragen wurden.

**Хавсралт****Дижитал шалгалтын нэмэлт журам**

Шалгалтын төвд дижитал шалгалт өгч байгаа тохиолдолд дараах журам үйлчилнэ:

**§ 19-өөс зөрөх заалт**

Герман хэлний дижитал шалгалтын УНШИХ болон СОНСОХ хэсгийн урьдчилан өгөгдсөн хариулт бүхий даалгавруудын гүйцэтгэлийг тестийн платформоор автоматаар үнэлнэ. Шалгалтын БИЧИХ хэсэгт зөвхөн заагдсан хэсэгт бичсэн эхүүдийг үнэлнэ.

**Zusätzliche Regelungen zu Online-Deutschprüfungen**

Wird die Prüfung online abgelegt, gilt abweichend Folgendes:

**1. Zusätzlich zu § 3:**

Vor der Anmeldung für Online-Deutschprüfungen ist die Durchführung eines Technik-Checks über den Link: <https://on.examity.com/V5/systemcheck> obligatorisch. Beim Buchungsprozess muss die Durchführung des Technik-Checks bestätigt werden. Details zu den technischen Voraussetzungen finden sich im Anhang der Durchführungsbestimmungen.

**2. Zusätzlich zu § 4:**

Bei Online-Deutschprüfungen wählen die Prüfungsteilnehmenden die für sie passende Uhrzeit direkt bei der Buchung aus. In Ländern mit mehreren Zeitzonen müssen die schriftliche und mündliche Online-Deutschprüfung in der gleichen Zeitzone gebucht werden.

**3. Abweichend von § 4**

Die Anmeldung von Minderjährigen für Online-Deutschprüfungen ist nicht erlaubt.

**4. Zusätzlich zu § 6:**

Erfolgt bei Online-Deutschprüfungen ein Prüfungsausschluss aufgrund der *Prüfungsordnung*, § 11 sowie der zusätzlichen Regelungen im Anhang, wird die Prüfungsgebühr nicht zurückerstattet.

Widerruft ein/-e Teilnehmende/-r eine zur Prüfungsdurchführung oder zur Sicherstellung der Prüfungssicherheit erforderliche Einwilligung, besteht kein Anspruch auf Rückerstattung von bereits entrichteten Prüfungsgebühren.

**Герман хэлний Онлайн шалгалтад үйлчлэх нэмэлт журам**

Онлайн буюу цахим шалгалт өгч буй тохиолдолд дараах журам үйлчилнэ:

**1. Зүйл § 3-ийн нэмэлт**

Герман хэлний онлайн шалгалтад бүртгүүлэхийн өмнө <https://on.examity.com/V5/systemcheck> линкээр орж техникийн нөхцөл байдлыг заавал шалгасан байна. Шалгалтад бүртгүүлэхдээ техникээ шалгасан гэдгээ баталгаажуулна. Техникт тавигдах шаардлагын талаарх дэлгэрэнгүйг Шалгалтын хэрэгжүүлэлтийн журмын хавсралтаас үзнэ үү.

**2. Зүйл § 4-ийн нэмэлт**

Онлайн шалгалтад оролцогчид бүртгүүлэхдээ өөрт тохирох цагийг сонгоно. Цагийн олон бүстэй оронд байгаа бол аман болон бичгийн онлайн шалгалтаа цагийн нэг бүсэд бүртгүүлнэ.

**3. § 4-өөс зөрөх заалт**

Насанд хүрээгүй хүнийг герман хэлний онлайн шалгалтад бүртгүүлэхийг хориглоно.

**4. § 6-ийн нэмэлт:**

Герман хэлний онлайн шалгалтаас Шалгалтын журмын § 11 болон хавсралтын нэмэлт журмын дагуу хасагдсан бол шалгалтын төлбөрийг буцаан олгохгүй.

Шалгалтад оролцогч шалгалтын зохион байгуулалт болон аюулгүй байдлыг хангахад шаардлагатай зөвшөөрлийг өгөхөөс татгалзсан бол шалгалтын төлбөрийг буцаан нэхэмжлэх эрхгүй болно.

**5. Zusätzlich zu § 8:**

Bei Online-Deutschprüfungen sind Vertreter\*innen oder Beauftragte des Goethe-Instituts zudem berechtigt, die Aufzeichnungen einzusehen.

**6. Zusätzlich zu § 11:**

Bei Online-Deutschprüfungen führen insbesondere folgende, jedoch nicht abschließend aufgelistete Szenarien zum Ausschluss von der Prüfung.

- Verwendung von technischen Geräten und Anwendungen, die nicht zu den technischen Voraussetzungen gehören (vgl. Anhang der *Durchführungsbestimmungen*)
- Abschaltung oder Ausfall von Webcam, Lautsprecher oder Mikrofon während der Prüfungsdurchführung
- Prüfungsbedingungen sind nicht adäquat (vgl. Anhang der *Durchführungsbestimmungen*): z.B. Prüfungsraum ist nicht ordnungsgemäß aufgeräumt
- eine Person/ein Haustier betritt den Prüfungsraum
- der/die Prüfungsteilnehmende verlässt den Raum ohne Absprache
- Prüfungsteilnehmende befolgen die Aufforderungen der Prüfungsaufsicht bzw. der Prüfenden nicht
- der/die Prüfungsteilnehmende ist während der Prüfung nicht ausreichend erkennbar (vgl. Anhang der *Durchführungsbestimmungen*)
- der/die Prüfungsteilnehmende hat unerlaubte Hilfsmittel versteckt (vgl. Anhang der *Durchführungsbestimmungen*).

**7. Abweichend zu § 19:**

Bei Online-Deutschprüfungen werden nur die Texte bewertet, die in das entsprechende Textfeld eingetragen wurden. Beim Prüfungsteil/Modul SCHREIBEN werden nur die Texte bewertet, die in das entsprechende Textfeld eingetragen wurden.

**8. Abweichend zu § 26**

Die gleichbleibend hohe Qualität der Prüfungsdurchführung wird durch regelmäßige Kontrollen der schriftlichen und mündlichen Prüfung durch Einsichtnahme in die Aufzeichnungen sichergestellt. Der/Die Prüfungsteilnehmende erklärt sich damit einverstanden.

**5. § 8-ЫН НЭМЭЛТ:**

Герман хэлний онлайн шалгалтад Гёте-Институтийн үүрэгт ажилтнууд бичлэгийг үзэх эрхтэй.

**6. § 11-ИЙН НЭМЭЛТ:**

Герман хэлний онлайн шалгалтаас дараах, хараахан гүйцэд жагсаагаагүй буй тохиолдлуудаас гарсан үед хасна.

- Шалгалтын техникийн нөхцөлд үл хамаарах (Шалгалтын хэрэгжүүлэлтийн журмыг харьцуулна уу) техник хэрэгсэл ашигласан бол
- Шалгалтын үеэр вэбкамер, чанга яригч, эсвэл микрофон унтарсан, хаагдсан бол
- Шалгалтын нөхцөл (Шалгалтын хэрэгжүүлэлтийн журмын хавсралттай харьцуулна уу) таарч тохирохоор хангагдаагүй бол, жишээ нь шалгалт өгч буй өрөөг журмын дагуу эмхлээгүй байх.
- Ямар нэг хүн/амьтан шалгалт өгч буй өрөөнд орж ирвэл
- Шалгуулагч өрөөг зөвшөөрөлгүйгээр орхин гарвал
- Шалгуулагч шалгалтын хянагчийн шаардлагыг биелүүлээгүй бол
- Шалгуулагч шалгалтын үеэр хангалттай сайн танигдахгүй бол (Шалгалтын хэрэгжүүлэлтийн журмын хавсралттай харьцуулна уу)
- Шалгуулагч зөвшөөрөгдөөгүй туслах хэрэгсэл нуусан бол (Шалгалтын хэрэгжүүлэлтийн журмын хавсралттай харьцуулна уу).

**7. § 19-өөс зөрөх заалт.**

Герман хэлний онлайн шалгалтны зөвхөн зохих хэсэгт бичсэн эхүүдийг үнэлнэ. Шалгалтын БИЧИХ хэсгийн зөвхөн зохих хэсэгт бичсэн эхүүдийг үнэлнэ.

**8. § 26-аас зөрөх заалт**

Шалгалтын хэрэгжилтийг чанарын өндөр түвшинд байнга байлгахын тулд аман болон бичгийн шалгалтын бичлэгийг үзэж хянах аргаар хяналт тавина. Шалгалтад оролцогч үүнийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

